



АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН САЙДЫН 2027 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот
2026 он

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

I. УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ

Улсын Их Хурлаас 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2027 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 34.8 их наяд төгрөг, төсвийн нийт зарлагын дээд хязгаарыг 36.5 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг - 1.7 их наяд төгрөгийн алдагдалтай, суурь тэнцлийг 2.3 их наяд төгрөгийн ашигтай байхаар тогтоосон бөгөөд Монгол Улсын эрдэс баялгийн салбар 2025 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 25%-ийг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 79%-ийг, нийт экспортын хэмжээний 93%-ийг, гадаадын шууд хөрөнгө оруулалтын (I-IX сар) 74%-ийг, улсын төсвийн орлогын 28%-ийг тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 оны төсвийн хязгаар батлах тухай” 265 дугаар тогтоолоор Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2027 оны төсвийн зарлагын дээд хязгаарын дүнг 95,860.8 сая төгрөг /*үүнээс: урсгал зардалд 50,560.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 45,300.0 сая төгрөг*/, 2027 оны төсвийн орлогын доод хязгаарын дүнг 308,725.8 сая төгрөг /*үүнээс: төсөвт төвлөрүүлэх орлого 263,298.9 сая төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлого 45,427.0 сая төгрөг*/ гэж баталсан.

Гэвч Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2027 оны төсвийн хязгаарын саналд 2027 оны төсвийн зарлагын дээд хязгаарын дүнг 183,831.3 сая төгрөг /*үүнээс урсгал зардалд 97,102.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 86,729.1 сая төгрөг*/ гэж хүргүүлсэн бөгөөд урсгал зардлын **65.73% буюу 63,821.3 сая төгрөг** нь газрын тосны бүтээгдэхүүний агуулах, сав шинээр барих, өргөтгөх хадгалах хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зориулж олгох арилжааны банкны зээлийн хүүгийн хөнгөлөлтөд Засгийн газраас олгох татаасны төлбөр, хөрөнгийн зардлын **83.19% буюу 72,152.1 сая төгрөг** нь геологийн судалгаа, эрлийн ажлын зардал байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төсвийн зарлагын дээд хязгаарын дүнг 95,821.2 сая төгрөг /*үүнээс: урсгал зардал 50,521.2 сая төгрөг, хөрөнгийн зардал 45,300.0 сая төгрөг*/ баталсан бөгөөд урсгал зардлын **39.59% буюу 20,000.0 сая төгрөг** нь газрын тосны бүтээгдэхүүний агуулах, сав шинээр барих, өргөтгөх хадгалах хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зориулж олгох арилжааны банкны зээлийн хүүгийн хөнгөлөлтөд Засгийн газраас олгох татаасны төлбөр, хөрөнгийн зардлын **100.0% буюу 45,300.0 сая төгрөг** нь геологийн судалгаа, эрлийн ажлын зардал юм.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монгол Улсын Хөгжлийн банк, 10 арилжааны банк хооронд 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Газрын тосны бүтээгдэхүүний стратегийн нөөцийн агуулах барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийн гэрээг байгуулж, хамтран ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 5 банк 18-19 зээлдэгчид 226,200 м.куб хүчин чадалтай агуулахад 260,110.89 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байгаа бөгөөд эдгээр зээлийн хүүгийн татаасны төлбөрт 2026 онд 10.52 тэрбум төгрөг, **2027 онд 24.67 тэрбум төгрөг**, 2028 онд

21.47 тэрбум төгрөг, 2029 онд 13.7 тэрбум төгрөг, 2030 онд 5.2 тэрбум төгрөг, **нийт 75.64 тэрбум төгрөг** төлөх үүрэг хүлээсэн. Мөн гэрээт арилжааны банкнууд дээр 2026 оны III, IV улиралд олгогдохоор 7 аж ахуйн нэгж, байгууллагын 55,400 м.куб хүчин чадалтай агуулахад 88,000.0 сая төгрөгийн зээлийн судалгаа хийгдэж байна. Эдгээр зээлийн хүүгийн татаасны төлбөрт 2026 онд 2.5 тэрбум төгрөг, **2027 онд 6.8 тэрбум төгрөг**, 2028 онд 5.4 тэрбум төгрөг, 2029 онд 3.9 тэрбум төгрөг, 2030 онд 2.2 тэрбум төгрөг, 2031 онд 0.48 тэрбум төгрөг, **нийт 21.62 тэрбум төгрөг** төлөх үүрэг хүлээнэ.

Ирэх 2027 онд 15 аж ахуйн нэгж, байгууллагын 196,500 м.куб хүчин чадалтай 319,912.0 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийн хүсэлт ирсэн байгаа ба эдгээрийн зээлийн хүүгийн татаасны төлбөрийг урьдчилсан тооцооллоор **2027 онд 24.55 тэрбум төгрөг**, 2028 онд 22.16 тэрбум төгрөг, 2029 онд 16.69 тэрбум төгрөг, 2030 онд 10.78 тэрбум төгрөг, 2031 онд 4.36 тэрбум төгрөг, **нийт 78.55 тэрбум төгрөг** төлөхөөр байна.

Геологийн салбарыг уул уурхайн салбараас түрүүлүүлэн хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчинг бүрдүүлэх, геологи, эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор гүйцэтгэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, уул уурхайн салбарыг ашигт малтмалын найдвартай нөөцөөр хангаж үйл ажиллагааг тогтвортой байлгах замаар эдийн засаг, нийгмийн суурь үндсийг бэхжүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд 24.1 тэрбум төгрөг, 2022 онд 23.5 тэрбум төгрөг, 2023 онд 22.3 тэрбум төгрөг, 2024 онд 24.6 тэрбум төгрөг, 2025 онд 20.0 тэрбум төгрөг, 2026 онд 40 тэрбум төгрөг, **нийт 154.5 тэрбум төгрөгийн** геологийн судалгаа, эрлийн хайгуулын ажлыг гүйцэтгэсэн байна.

Геологийн зураглал, эрэл-үнэлгээ, агаар-сансрын тандан судалгаа, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн болон бусад региональ судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэснээр нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг танин мэдэж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах чухал ач холбогдолтой.

Тиймээс Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2027 оны төсвийн төслийн саналд геологийн судалгаа, эрлийн хайгуулын зардлыг **65.2 тэрбум төгрөг**, мөн тус зардлыг 2028-2029 оны төсвийн төсөөллийн саналд **2028 онд 71.48 тэрбум төгрөг, 2029 онд 65.98 тэрбум төгрөгийг** байхаар тооцоолж хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5 дахь заалтыг баримтлан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2027 оны төсвийн төслийг ТМ-01 маягтын дагуу боловсруулж, хүргүүлсэн болно.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

МАЯГТ ТМ-01. ТӨСВИЙН САНАЛ /мян.төг/

НИЙТ ЗАРДАЛ	2026 батлагдсан	2027 хязгаар баталсан	2027 ТЕЗ Санал	Хязгаараас давсан санал /ТЕЗ/
-------------	--------------------	--------------------------	-------------------	-------------------------------------

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД /зардал/	<u>95,821,176.1</u>	<u>95,860,758.1</u>	<u>170,417,932.6</u>	<u>74,557,174.5</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	50,521,176.1	50,560,758.1	94,749,581.0	44,188,822.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,433,190.8	22,642,976.3	25,125,613.5	2,482,637.2
УРСГАЛ ШИЛЖИЛЭГ	5,721,089.3	5,550,885.8	5,509,871.5	- 41,014.3
ТАТААС Газрын тосны компанид олгох зээлийн хүүгийн хөнгөлөлт	20,000,000.0	20,000,000.0	61,747,200.0	41,747,200.0
ТАТААС /Төлөөлөгчийг дэмжих үйл ажиллагаа/	2,366,896.0	2,366,896.0	2,366,896.0	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,300,000.0	45,300,000.0	75,668,351.6	30,368,351.6
Тоног төхөөрөмж			4,353,463.3	4,353,463.3
ТЭЗҮ-Зураг төсөв			3,241,000.0	3,241,000.0
Цахим систем			2,910,000.0	2,910,000.0
Бусад хөрөнгө /геологи судалгаа, эрэл/	45,300,000.0	45,300,000.0	65,163,888.3	19,863,888.3

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2026 батлагдсан	2027 хязгаар баталсан	2027 ТЕЗ Санал	Хязгаараас давсан санал /ТЕЗ/
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД /эх үүсвэр/	<u>95,821,176.10</u>	<u>95,860,758.10</u>	<u>170,417,932.60</u>	<u>74,557,174.5</u>
Улсын төсвөөс санхүүжих	50,394,221.7	50,433,803.7	105,127,089.9	54,693,286.2
Улсын төсвөөс санхүүжих	50,394,221.7	50,433,803.7	105,127,089.9	54,693,286.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	45,426,954.4	45,426,954.4	65,290,842.7	19,863,888.3
Үндсэн үйл ажиллагааны орлого /АМГТГ/	5,426,954.4	5,426,954.4	5,426,954.4	0.0
Үндсэн үйл ажиллагааны орлого /сонгон/	40,000,000.0	40,000,000.0	59,863,888.3	19,863,888.3

Байгууллагаар /урсгал зардал/	2026 батлагдсан	2027 хязгаар баталсан	2027 ТЕЗ Санал	Хязгаараас давсан санал /ТЕЗ/
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	32,384,980.7	32,328,973.1	74,076,173.1	41,747,200.0
Ашигт малтмал, газрын тосны газар	12,917,463.0	12,957,072.0	14,955,076.6	1,998,004.6
Үндэсний геологийн алба	1,563,115.8	1,610,672.6	2,054,290.9	443,618.3
Цбмийн энергийн комисс	3,655,616.6	3,664,040.4	3,664,040.4	0.0
Хөрөнгө оруулалт	0.0	0.0	10,504,463.3	10,504,463.3
Бусад хөрөнгө /геологи судалгаа, эрэл/	45,300,000.0	45,300,000.0	65,163,888.3	19,863,888.3
Нийт дүн	<u>95,821,176.1</u>	<u>95,860,758.1</u>	<u>170,417,932.6</u>	<u>74,557,174.5</u>

Цалингийн сан	2026 батлагдсан	2027 хязгаар баталсан	2027 ТЕЗ Санал	Хязгаараас давсан санал /ТЕЗ/
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	4,867,040.4	4,896,811.7	5,841,139.8	944,328.1

Ашигт малтмал, газрын тосны газар	6,626,914.6	6,698,269.6	8,646,643.1	1,948,373.5
Үндэсний геологийн алба	1,281,608.1	1,325,769.7	1,769,388.0	443,618.3
Цөмийн энергийн комисс	1,167,107.2	1,171,957.0	1,495,039.4	323,082.4
Нийт дүн	13,942,670.3	14,092,808.0	17,752,210.3	3,659,402.3

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2027 оны төсвийн саналыг нэгтгэхэд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2027 оны төсвийн төслийн саналын зардлын нийт дүн 170,809.4 сая төгрөг болж, 2027 онд батлагдсан төсвийн зарлагын дээд хязгаарын дүнгээс 74,948.6 сая төгрөгөөр давсан бөгөөд 2027 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын дагуу дараах задаргааг боловсрууллаа. Үүнд:

- Ашигт малтмал газрын тосны газрын цалингийн зардалд: 1,652.4 сая төгрөг
- Үндэсний геологийн албаны Цалингийн зардалд: 394.3 сая төгрөг
- Зээлийн хүүгийн хөнгөлөлтийн татааст: 41,747.0 сая төгрөг
- Геологийн судалгаа, эрлийн ажил /Бусад хөрөнгө/ 19,863.9 сая төгрөг
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд: 10,504.5 сая төгрөг

Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 225, 224, 226 дугаар тогтоолоор төрийн албаны цалинг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан ба 2026, 2027 оны төсөв, 2027 оны төсвийн хязгаарт орж батлагдаагүй болно. 2027 оны төсвийн төсөлд АҮЭБЯ, ЦЭК цалингийн нэмэгдлийг бусад зардлаас хэмнэх замаар төсвийн хязгаарт багтааж хүргүүлсэн. АМГТГ, ҮГА-ны цалингийн зардлын нэмэгдлийг төсвийн хязгаарт багтаах боломжгүй байна.

II. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилт сүүлийн дунд хугацаанд батлагдаж байгаагүй бөгөөд 2025 оны улсын төсөвт салбарын тоног төхөөрөмжийн зардалд 984.0 сая төгрөг батлагдаж, тухайн жилдээ хэрэгжиж дууссан байна.

Төсвийн тухай хуульд заасан цаглабрын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн санал, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 оны төсвийн хязгаарын санал боловсруулж, холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх үед манай салбарт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санал ирээгүй болно.

Үүний умаас Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 265 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 оны төсвийн хязгаарт манай салбарт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгө батлагдаагүй хэдий ч 2027 оны төсвийн төслийн саналыг боловсруулахад ирүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтыг баримтлан нэгтгэн боловсруулсан болно.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2027 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд 15,218.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2027 онд 11,997.4 сая төгрөгийн санхүүжилт бүхий 6 төсөл, арга хэмжээ тусгасан. Үүний 1 нь ТЭЗҮ, 2 нь тоног төхөөрөмж, 3 нь цахим систем ангилалд хамаарна.

сая.төг

№	Төсөл, арга хэмжээ	Ангилал	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2027 онд санхүүжих дүн	2028 онд санхүүжих дүн
1	Цөмийн эрчим хүчний станцын дэд бүтцийн ТЭЗҮ боловсруулах	ТЭЗҮ	2027	2028	7,955.0	4,714.0	3,241.0
2	"Цацрагийн аюулыг үнэлэх улсын алба"-ны багаж төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Тоног төхөөрөмж	2027	2027	3,570.8	3,570.8	-
3	Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, хяналтын цахим систем	Цахим систем	2027	2027	560.0	560.0	-
4	Багаж, техник, тоног төхөөрөмж АМГТГ	Тоног төхөөрөмж	2027	2027	782.60	782.60	-
5	E-MPResources нэгдсэн систем/	Цахим систем	2027	2027	1,400.0	1,400.0	-
6	Газрын тосны хайгуул, ашиглалтын тайлан, төлөвлөгөө хүлээн авах цахим систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	Цахим систем	2027	2027	950.0	950.0	-
	Нийт дүн				15,218.4	11,997.4	3,241.0

Эдгээр төсөл, арга хэмжээ нь цөмийн эрчим хүчний суурь судалгаа, цацрагийн ослын үеийн бэлэн байдал, салбарын цахим шилжилт, мэдээллийн нэгдсэн систем, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ба "Алсын хараа-2050", Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй нийцэж байна.

Төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээр салбарын чадавх, цахим засаглал, аюулгүй байдал болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах нөхцөл бүрдэнэ.

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС